



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 03 сарын 14 өдөр

Дугаар А/99.

Хэрлэн сум

Захирамж хүчингүй болгох тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.3 дахь заалтуудыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хэнтий аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2018 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн 127/ШШ2018/0005 дугаартай захирамж гарсантай холбогдуулан "Кенза трейд" ХХК-ний эзэмшлийн Хэрлэн сумын 3 дугаар баг, Тэмүүжин цогцолборын сургуулийн зүүн талд байрлах худалдаа, үйлчилгээний зориулалттай газраас 10759 м² газрыг иргэн У.Одхүүд шилжүүлэн эзэмшүүлсэн аймгийн Засаг даргын 2017 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн А/183 дугаартай захирамжийг хүчингүй болгосугай.

2. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан дээрх газар дээр байрлаж буй "Дөрвөн Улирал-Хэнтий" ХХК-ний газар эзэмших эсэх асуудлыг шийдвэрлэхийг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга /Д.Баярхүү/-д үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга /Э.Мөнх-Эрдэнэ/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА